ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн тайлан
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1 Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг байгууллагын албан ёсны цахим хуудас, сошиал суваг, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбар зэрэгт байрлуулж олон нийтэд хүргэх	Тус төвийн амбулаторийн тасгийн цахим бүртгэлийн хэсгийн мэдээллийн самбар, дэлгэц, төвийн албан ёсны цахим групп, дотоодын мессэнжер групп зэргээр дамжуулан АТГ-аас бэлтгэсэн шторк, нийтлэл, зурагт хуудас зэргийг төвийн байршуулан мэдээллэн ажилласан. Хавдар судлалын үндсэний төвийн олон нийтэд зориулсан 75М дагагчтай “Хавдар судлалын үндэсний төв” фэйсбүүкийн группд АТГ-ын олон нийтэд зориулан гаргасан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн талаар мэдээ, мэдээллийг байршуулсан.  Хавдар судлалын үндэсний төвийн эмч, ажилтнуудын 650 орчим гишүүнтэй фэйсбүүк группд АТГ-аас гаргасан 4-н контентийг байршуулсан. Үүнд:

			1. Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд танд ямар хүндрэл, бэрхшээл тулгардаг вэ? 2. Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт 3. Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт 4. Давхар ажил эрхлэлттэй холбогдсон хязгаарлалт 
		1.2 Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	2025 онд “Тасгийн, албаныхаа үйл ажиллагааг суртчилах” уриан дор нээлттэй хаалганы өдөрлөгийг төлөвлөгөөний дагуу нийт 18 тасаг, алба өөрсдийн үйл ажиллагааг таниулан сурталчилах, үйлчлүүлэгч болон түүний ар гэр, ард иргэдэд тусламж, үйлчилгээний талаарх мэдлэг эмчийн үзлэг, зөвлөгөө, хоол зүйчийн зөвлөгөө, хөдөлгөөн засалчийн зөвлөгөө, сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлж, Эрүүл мэндийн боловсрол олгох сурталчилгааны материал 1100ш тарааж хамрагдсан хүн бүрт эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл өгөх зэрэг тусламж үйлчилгээг давхардсан тоогоор нийт 1500 хүнд үзүүлсэн байна.

			Төвийн захирлын зөвлөл болон тасаг, албадын дарга нар 2025 онд хуваарийн дагуу нийт 4 удаа үйлчлүүлэгч болон ар гэрийнхэнтэй уулзах уулзалтад оролцон 330 гаруй эмчлүүлэгч, тэдний ар гэрийнхэний санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн ажиллаж зарим шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг хүргэсэн. Мөн оролцогч нараас сэтгэл ханамжийн судалгааг QR код болон цаасан хэлбэрээр авч шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. Үүнд: 1. БМАБА-наас зогсоолын хувьд өргөтгөлийн барилгын ажил явагдаж байгаа үүнтэй холбоотой зарим зогсоолуудыг хаасан, барилгын ажил дуусахаар зогсоол эргээд хэвийн болно. Зогсоолын төлбөрийг ХСҮТ авдаггүй гэрээгээр албан байгууллага ажиллуулдаг талаарх тайлбар мэдээлэл. 2. Сувилахуйн албанаас Эргэлтийн цагийн хуваарь орой 20:00 цаг хүртэл байдаг 20:00 цагаас өмнө гэрээсээ эргэлтээ авч болноо түүнээс хойш эргэлт оруулахгүй журамтай байдаг талаарх мэдээлэл. 3. Амбулаторийн тасаг Хөтөч, цахим ажилтнуудад харилцаа хандлагын талаарх сургалт зохион явуулах, стресс менежмент, хэцүү үйлчүүлэгчтэй хэрхэн харилцах вэ? гэх мэт. Мөн цаг захиалгын 7272-4000 утсыг тогтмол хэвийн ажиллуулдаг байх, хариуцсан ажилтнуудад хяналт тавих, энэ талаарх гомдол ихэнх хувийг эзлээд байгаа тул зайлшгүй анхаарах. 4. Үйлчлүүлэгчийг дэмжих албанд: Асуумжаар дийлэнх үйлчлүүлэгч болон ар гэрийн зүгээс сэтгэлзүйч, хоолзүйч, нийгмийн ажилтнуудаас тусламж, үйлчилгээ аваагүй гэж хариулжээ. Иймд дээрх төрлийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг иргэд үйлчлүүлэгчдэд сурталчлан таниулах, төвийн цахим вэб хуудсаар мэдээлэх зэрэг үйл ажиллагааг явуулан, эрүүл мэндийн тусламж ,үйлчилгээний нэг хэсэг тул жигд, хүртээмжтэйгээр ажиллаж хэвших.

			5. Хөнгөвчлөх эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгчийн ар гэрийн хүсэлтээр эмчлэгч эмч, ТХНСММЗТ-ийн эрхлэгч, Хими болон Туяа эмчилгээний тасгийн эрхлэгч, ЭЭДЗ, ЭМТҮЧАБА дарга нар биечлэн уулзаж эмчилгээний талаарх зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. 6. Эмч ажилчдын харилцаа, хандлагад цаашид анхаарч ажиллах талаар бүх эмч нарын ярианд Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал анхааруулан, сануулж ажилласан.
		1.3 Авлигын эсрэг хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн талаар эрүүл мэндийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудад сургалт зохион байгуулах	2025 онд ХСҮТ-ийн удирдах албан тушаалтан, өөр удирдах албан тушаал шилжин болон дэвшин ажиллах болсонтой холбогдуулан 11-н албан тушаалтан ХАСУМ, 7-н албан тушаалтан ХАСХОМ шинэчлэн гаргуулсны үндсэн дээр баталгаажуулан ажилласан ба тэдгээр ажилтнуудад тухай бүрд нь зөвлөгөө өгсөн.
2.	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.1 “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	Уг ажлын хүрээнд “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх олон нийтийн байгууллагын зарыг олон нийтэд мэдээллэсэн боловч ямар нэг санал, хүсэлтээ ирээгүй болно.
		2.2 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд эрүүл мэндийн салбарын нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллагуудыг үйл ажиллагааг нэмэгдүүлэх	Тус төвд хамааралгүй болно.
		2.3 Эрүүл мэндийн салбарын мэргэжлийн нэгдсэн холбоог байгуулж замаар төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах	Тус төвд хамааралгүй болно.
		2.4 Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах	Тайлант онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ байхгүй бөгөөд төсөв санхүүгийн ил тод байдлыг шилэн данс болон www.tender.gov.mn сайтад тухай бүрд нь мэдээллийг үнэн зөв байршуулсан. Жилд шилэн дансанд давхардсан тоогоор 622 мэдээ байршуулсан. Тендэр сайтанд 11 төрлийн тендэр зарласан.
		2.5 Эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүнд суртал, ойлгомжгүй байдлыг арилгах зорилгоор цахим үйлчилгээг шинээр нэвтрүүлэх	ХСҮТ-ийн цахим хуудсанд төвийн эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой тусламж үйлчилгээний өргөдөл, гомдол санал, хүсэлтийг хүлээн авах хэлбэрүүд болон шийдвэрлэлтийн талаар тайланг мэдээг иргэд, олон нийт нээлттэй харах боломжийг бүрдүүлсэн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 

			талаарх мэдээлэлтэй 75 иргэн, олон нийт танилцсан байна.
		2.6 Авлигатай тэмцэх газартай хамтран Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангах	Тус төвд хамааралгүй болно.
3.	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1 Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байхад байгууллагын удирдлагын баг тасралтгүй хяналт тавих, зөрчил үүссэн нөхцөл байдал яаралтай арга хэмжээ авч ажиллах	2025 оны 2-р улиралд Авлигатай тэмцэх газраас 2 ажилтан томилогдон ирж 1 сарын хугацаанд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, бусад үйл ажиллагаатай танилцаж заавар, зөвлөгөө өгсөн. 2025 онд тус төвөөс 11 албан тушаалтныг удирдах албан тушаалд томилохдоо ХАСУМ-ыг АТГ-аар хянуулахаар албан хүсэлт хүргүүлсны дагуу хариуг үндэслэн 7-н албан тушаалтныг томилон ажиллуулсан. 3 ажилтан ажлын байрны тодорхойлолт болон хуульд заасан шаардлага хангаагүй тул томилогдоогүй. 1 албан тушаалтны ХАСУМ хянасан тухай мэдэгдэл ирээгүй хүлээгдэж байна. 2025 онд 6 удирдах албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэгийг урьд оны байдлаар гаргуулж баталгаажуулсан. 2025 онд 2 удирдах ажилтан ХАСХОМ-т орсон хэмжээний өөрчлөлтийг мэдээллэсэн. Төвийн хэмжээнд авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн 2 төрлийн шторк хийж төвийн олон нийтэд зориулсан цахим группд байршуулсан.
		3.2 Салбарын хэмжээнд гарч буй өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг нэгтгэн гомдлыг шалтгаан нөхцөлийг тодорхойлох	Өргөдөл, гомдлын тайлан Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/50 тоот тушаалаар батлагдсан “Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журам”, ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2021 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн А/12 тоот тушаалаар батлагдсан “Иргэдээс ирүүлсэн эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт - 206 гомдол, санал, хүсэлт, өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлээд байна. Үүнээс: • Санал – 25 • Гомдол – 153 • Өргөдөл – 28 “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 1-т заасны дагуу иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, гаргах эрхийн

			хэрэгжилтийг сайжруулах зорилгоор санамж, зурагт хуудас, талархлыг самбар, санал хүсэлтийн хайрцгийг амбулаторийн хүлээлгийн танхим, эмчилгээний тасгууд болон төвийн цахим хуудсанд байрлуулан мөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны утасны дугаар, цахим хаяг, өрөөний дугаар бүхий нэрийн хуудсыг сувилагчийн пост, хүлээлгийн заал, хүлээн авах зэрэг үйлчлүүлэгч олноор үйлчлүүлдэг газруудад байрлуулан ажиллаж байна. Тус төвийн 2025 оны III улиралд ирсэн нийт өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэг дахин буурсан үзүүлэлттэй байна. 2024 оны III улиралд ирсэн нийт гомдлын 48.8% нь Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой гомдол буюу эмнэлгийн хүлээгдэл байсан нь энэ оны III улиралд 8.6%-иар буурсан. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бууруулах чиглэлээр дараах ажлууд хийгдээд байна. Үүнд: ○ Туяа эмчилгээний хүлээгдэл чирэгдлийг бууруулах ажлыг төлөвлөлт нь дээр 2 сарын хүлээгдэл байсан нь одоо 2 хоног болж буурсан. Үйлчлүүлэгч эмчилгээндээ туяа эмчилгээний заалт гарснаас хойш 7-10 хоногийн дотор эмчилгээндээ ордог болсон. ○ Амбулаторийн үзлэгийн бүтцэд анхан үзлэгийг цагийг нэмж, шууд үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн. ○ Цахим бүртгэгч нар өдөр бүр бүх кабинетад сул цаг гаргаж бэлтгэх (1-2), шаардлагатай тохиолдолд кабинетын эмчид шууд хандахаар зохицуулалт хийсэн. ○ Амбулаторийн хөхний кабинет дээр нэмж 3 кабинет нээж ажиллаж байна. ○ Хавдрын тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүлээгдлийг бууруулах ажлын хүрээнд ЭМЯ-ны зөвшөөрлөөр төвийн хажууд байрлах хувийн хэвшлийн 4-р эмнэлэгт түр шилжин байршиж тусламжийн тасралтгүй байдлыг хангаж ажилласан. ○ Амбулаторийн хүлээгдэл энэ оны III улирлын 8.7 хоног байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 15.3 хоногоор буурсан үзүүлэлттэй байна. Амбулаторид үзүүлэхээр ирж буй анхан үйлчлүүлэгчдийг “АНХАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ” үнэмлэхээр үйлчилж нийт үйлчлүүлэгчийн 68% нь тухайн ирсэн өдрөө үзлэг шинжилгээнд орж байна. ○ Хүлээгдлийг бууруулах, төвлөрлийг сааруулах ажлын нэг болох “Хойд бүсийн хавдрын оношилгоо эмчилгээний төв”-тэй болж байгаа

			ба энэ нь ХСҮТ-ийн хүлээгдлийг 10-15% бууруулах судалгаа гарч байна. “Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний төв”-д 5 чиглэлээр үзлэгийн кабинет нээж 2025 оны 9-р сарын 15-ны өдрөөс эхлэн ажиллаж байна. Мөн амбулаториор онош тодруулахаар ирсэн иргэд оношилгоо шинжилгээнд орохоор 14-21 хоног хүлээдэг байсан бол ХБОЭТ-д оношилгоо хийлгэж /3-4 хоногт/ онлайнаар холбогдон олон эмч нарын хамтарсан зөвлөгөөн хийж дараагийн эмчилгээг сонгох, эмчилгээний товийг тогтоох, цаг хугацаа, эдийн засгийг хэмнэх чухал ач холбогдолтой байна. ○ Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол өмнөх оны мөн үед 22% байсан бол энэ онд 20.7% болж 1.3%-иар буурсан. ХСҮТ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооноос эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлагыг сайжруулах, ёс зүйн алдаа зөрчлөөс сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг тасралтгүй зохион байгуулж байна. Уг ажлын хүрээнд ёс зүйн салбар хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургагч багш” бэлтгэх сургалтыг амжилттай зохион байгуулж, 31 эмч, ажилтныг сургагч багшаар бэлтгэсэн. Сургагч багш нар нь өөрсдийн ажилладаг тасаг албанд ёс зүйн хичээл заана. ○ Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой хүсэлт өмнөх онд 1.5% байсан бол энэ оны мөн үед 1.2% болж 0.3%-иар буурсан. Харин аппарат тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй холбоотой гомдол өмнөх оны хагас жилд 3.6% байсан бол энэ онд 23.8% болж 20.2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Эхний улиралд КТГ, рентген, маммограф, артрозын шарлагын аппаратын эвдэрсэн холбоотой байна. Одоогийн байдлаар артрозын шарлагын аппаратаас бусад тоног төхөөрөмжүүд бүгд хэвийн ажиллаж байна.
		3.3 Төгсөлтийн дараах сургалтын элсэлт, элсэлтийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулж эрсдэлийг бууруулах	Эрүүл мэндийн хөгжлийн төгсөлтийн дараах сургалтын элсэлт, элсэлтийн шалгалт зохион байгуулдаг ба тус төвд хамааралгүй болно.
4.	Байгууллагын удирдлагын авлигатай	4.1 Эрүүл мэндийн байгууллага бүр авлигын эсрэг төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хагас, бүтэн жилээр тайлагнах	2025 оны 12-р сард ХСҮТ-ийн үйл ажиллагааны жилийн тайлангийн хурал Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг танилцуулахаар төлөвлөж байна.

	тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх		
		4.2 Авлигатай тэмцэх, соён гэгээрүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр байгууллагын удирдлага шинэ ажил санаачлан хэрэгжүүлж, сурталчлах	Төвийн хэмжээнд авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн 2 төрлийн шторк хийж төвийн олон нийтэд зориулсан цахим группд байршуулсан. 1. Авлигаас ангиад байх, бэлэн мөнгө, эд зүйл өгөхийг хориглосон видео шторкийг гаргасан. 2. АТГ-тай хамтарч “Авлигаас ангид байх, шударга байдлыг уриалсан” видео контентыг хийж төвийн зургийг авч дууссан ба 12 сард багтаан олон нийтэд хүргэхээр төлөвлөсөн болно.
		4.3 Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл шинээр олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчилж боловсруулах	Тус төв нь тусгай зөвшөөрөл шинээр олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааны эрхэлдэггүй болно.

Хянасан. **Хавдар судлалын үндэсний төвийн захирал** **Ц.Батболд**

Тайлан гаргасан. **Эрх бүхий албан тушаалтан,**
Хүний нөөц, хөгжлийн албаны дарга **Д.Мөнхтуяа**